



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022 /89/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Эрдэнэт хот
2022 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ
Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитор: Т.Болормаа
Утас: 70350757 Цахим хаяг: bolormaat@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
4. Аудитын илрүүлэлт	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.25 № 35
танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН МЭДЭЭЛЭЛ
ШУУРХАЙ УДИРДЛАГЫН
ТӨВИЙН ЗАХИРАЛ Н.ГАНСҮХ
ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>22,662,236.00</u>	<u>23,890,536.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	22,662,236.00	23,890,536.00
351	Түүхий эд материал	22,418,236.00	23,389,236.00
35110	Тусгай зориулалттай материал	22,418,236.00	23,389,236.00
354	Хангамжийн материал	244,000.00	501,300.00
35410	Бичиг хэргийн материал	44,000.00	240,000.00
35420	Аж ахуйн материал	-	31,300.00
35440	Түлш, шатах тослох материал	200,000.00	230,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,207,802,230.11</u>	<u>948,685,028.57</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,207,802,230.11	948,685,028.57
392	Биет хөрөнгө	1,079,725,965.39	854,996,163.29
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,900,000.00	5,900,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(393,333.28)	(688,333.24)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,165,859,759.00	1,174,488,159.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(209,798,027.66)	(436,576,625.52)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,867,392.00	46,532,857.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(3,493,652.11)	(7,213,664.47)
39214	Бусад үндсэн хөрөнгө	122,090,570.00	122,090,570.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(28,306,742.56)	(49,536,799.48)
393	Биет бус хөрөнгө	128,076,264.72	93,688,865.28
39301	Програм хангамж	88,100,000.00	88,100,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(23,493,333.28)	(41,113,333.24)
39303	Бусад биет бус хөрөнгө	67,069,598.00	67,069,598.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(3,600,000.00)	(20,367,399.48)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,230,464,466.11</u>	<u>972,575,564.57</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,230,464,466.11</u>	<u>972,575,564.57</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,230,464,466.11	972,575,564.57
512	Хуримтлагдсан үр дүн	1,230,464,466.11	972,575,564.57
51210	Өмнөх үеийн үр дүн	1,230,464,466.11	1,230,464,466.11
51220	Тайлант үеийн үр дүн	-	(257,888,901.54)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,230,464,466.11</u>	<u>972,575,564.57</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	661,946,971.00	173,495,265.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	502,585,722.00	27,293,865.00
120	Нийтлэг татварын бус орлого	502,585,722.00	27,293,865.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	502,585,722.00	27,293,865.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	502,585,722.00	27,293,865.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	159,361,249.00	146,201,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,374,949.00	14,960,000.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,374,949.00	14,960,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	147,986,300.00	131,241,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	147,986,300.00	131,241,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	369,349,620.11	431,384,166.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	369,349,620.11	431,384,166.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	334,925,370.14	428,647,135.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	88,912,654.00	91,098,879.00
210101	Үндсэн цалин	88,912,654.00	78,114,844.00
210102	Нэмэгдэл	-	12,984,035.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,866,772.56	11,810,054.56
210201	Тэтгэврийн даатгал	7,557,575.72	8,181,334.22
210202	Тэтгэмжийн даатгал	889,126.54	910,988.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	671,743.82	728,791.10
210204	Ажилгүйдлийн даатгал	159,108.35	180,812.71
210205	Эрүүл мэндийн даатгал	1,589,218.13	1,808,127.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,522,572.47	17,076,673.83
210301	Гэрэл, цахилгаан	8,854,095.25	14,485,107.44
210302	Түлш, халаалт	1,222,060.41	1,103,009.91
210303	Цэвэр, бохир ус	446,416.81	506,806.48
210304	Байрны түрээс	-	981,750.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,267,300.00	5,316,221.60
210401	Бичиг хэрэг	689,700.00	547,250.00
210402	Тээвэр, шатахуун	900,000.00	1,170,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,131,900.00	905,971.60
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	60,000.00	110,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,485,700.00	2,583,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	16,155,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	1,195,000.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	14,960,000.00
2107	Томилолт, зочны зардал	190,800.00	500,000.00
210702	Дотоод албан томилолт	190,800.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	300,000.00	279,240.00

Шуурхай удирдлагын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300,000.00	279,240.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	212,865,271.11	286,411,066.54
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	212,865,271.11	286,411,066.54
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,424,249.97	2,737,031.01
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	33,424,249.97	1,737,031.01
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	33,424,249.97	1,737,031.01
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>292,597,350.89</u>	<u>(257,888,901.54)</u>
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>292,597,350.89</u>	<u>(257,888,901.54)</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,230,464,466.11	1,230,464,466.11
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-		-
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	1,230,464,466.11	1,230,464,466.11
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(257,888,901.54)	(257,888,901.54)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	972,575,564.57	972,575,564.57

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	164,764,049.00	146,745,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	164,764,049.00	146,745,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,374,949.00	14,960,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,374,949.00	14,960,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	147,986,300.00	131,241,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	147,986,300.00	131,241,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	5,402,800.00	544,000.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	5,402,800.00	544,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	164,764,049.00	146,745,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	164,764,049.00	146,745,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	124,936,999.03	143,464,368.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	88,912,654.00	91,098,879.00
210101	Үндсэн цалин	84,136,980.00	77,232,002.00
210102	Нэмэгдэл	4,775,674.00	13,866,877.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,866,772.56	11,810,054.56
210201	Тэтгэврийн даатгал	7,557,575.72	8,181,334.22
210202	Тэтгэмжийн даатгал	889,126.54	910,988.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	671,743.82	728,791.10
210204	Ажилгүйдлийн даатгал	159,108.35	180,812.71
210205	Эрүүл мэндийн даатгал	1,589,218.13	1,808,127.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,522,572.47	17,076,673.83
210301	Гэрэл, цахилгаан	8,854,095.25	14,485,107.44
210302	Түлш, халаалт	1,222,060.41	1,103,009.91
210303	Цэвэр, бохир ус	446,416.81	506,806.48
210304	Байрны түрээс	-	981,750.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,342,800.00	6,539,521.60
210401	Бичиг хэрэг	733,700.00	743,250.00
210402	Тээвэр, шатахуун	1,100,000.00	1,200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,131,900.00	905,971.60
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	60,000.00	110,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,317,200.00	3,580,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,801,400.00	16,160,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,200,000.00	1,200,000.00
210604	Урсгал засвар	6,601,400.00	14,960,000.00
2107	Томилолт, зочны зардал	190,800.00	500,000.00
210702	Дотоод албан томилолт	190,800.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	300,000.00	279,240.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300,000.00	279,240.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,827,049.97	3,281,031.01
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,402,800.00	1,544,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	5,402,800.00	544,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	33,424,249.97	1,737,031.01
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	33,424,249.97	1,737,031.01
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	=
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Болормаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Мэдээлэл шуурхай удирдлагын төв нь аймгийн хэмжээнд иргэд, аж ахуйн нэгжүүдээс гэмт хэрэг захиргааны зөрчил, гал түймэр, гамшиг осол, эмнэлгийн яаралтай тусламжийн талаарх мэдээ мэдээллийг шуурхай хүлээн авч, шуурхай удирдлага зохицуулалт хийх, хяналт тавих, мэдээ мэдээлэл боловсруулах үйл ажиллагаа явуулдаг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль 2021 оны 12 дугаар сарын 24-ны өдөр өөрчлөлт орсон.
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр өөрчлөлт орсон.
- Төрийн албаны тухай хууль 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдөр өөрчлөлт орсон.
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтан ажилладаггүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 127,247.8 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 2,544.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 1,908.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 257,888.9 мянган төгрөгөөр буюу 21 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	
Бараа материал	22,662.2	23,890.5	1,228.3
Үндсэн хөрөнгө	1,207,802.2	948,685.0	(259,117.2)
Нийт хөрөнгө	1,230,464.5	972,575.6	(257,888.9)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,230,464.5	972,575.6	(257,888.9)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,230,464.5	972,575.6	(257,888.9)

Бараа материалын данс 23,890.5 мянган төгрөг болж 1,228.3 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материал шинээр нэмж орлого авснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 948,685.0 мянган төгрөг болж 259,117.2 мянган төгрөгөөр буурсан нь 27,293.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил

орлого авч, тайлант оны хуримтлагдсан элэгдэл 269,085.1 мянган төгрөг нэмж бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 972,575.6 мянган төгрөг болж 257,888.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 488,451.7 мянган төгрөгөөр буюу 26 хувиар буурсан, нийт зардал өмнөх оноос 62,034.5 мянган төгрөгөөр буюу 16.8 хувиар тус тус өссөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 255,717.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 255,717.1 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 128,469.3 мянган төгрөгөөр бууруулан 127,247.8 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх мэдээллийн нэгдсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр 131,241.4 мянган төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн төсвөөс авч, урсгал үйл ажиллагаанд 129,504.4 мянган төгрөгийг зарцуулж, 1,737.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 129,504.4 мянган төгрөг буюу батлагдсан төсвөөс 103.1 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 3,992.3 мянган төгрөгөөр хэтэрч, оны эцэст нэмэгдэл төсвийг шийдвэрлэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Эрдэнэт сангаас 5,000.0 мянган төгрөг, Орон нутгийн хөрөнгө оруулалт болзошгүй аваарын зардлаас Засаг даргын А/647 захирамжаар 9,960.0 мянган төгрөг нийт 14,960.0 мянган төгрөгийн хотын нэгдсэн камержуулалтын засварын зардлын санхүүжилтийг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудит хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Мэдээлэл шуурхай удирдлагын төв нь 2021 онд нийт 175,239.4 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2 мэдээллийг мэдээлэх хугацаа болоогүй, 164,374.0 мянган төгрөгийн 149 мэдээллийг ил тод байршуулж, хуулийн хугацаанд мэдээлсэн, 10,865.4 мянган төгрөгийн 1 ажил гүйлгээг орхигдуулсан байсныг аудитын явцад залруулан бүртгүүлсэн.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, харин шатахуун зарцуулалтын анхан шатны баримт, норм тооцсон байдал, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардлын зарцуулалт зэргийг Зам тээврийн хөгжлийн сайдын 390 дүгээр тушаал, Сангийн сайдын 2021 оны “зардлын эдийн засгийн ангилал батлах тухай” 190 дүгээр тушаалын хүрээнд шалгасан зүйлийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 190.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 1,200.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж хэрэгжилтийг 100 хувьтай хангуулсан байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Акт	1	190.0	1	190.0			
Албан шаардлага							
Зөвлөмж	1	1,200.0	1	1,200.0			
Нийт дүн	2	1,390.0	2	1,390.0			

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 15,587.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 10,865.4 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 1,170.0 мянган төгрөгт 1 албан шаардлага, 3,552.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг материаллаг бус гэж үзсэн тул 2 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа:

Шилэн дансны цахим сайтад 5 сарын орлогын 10,865.4 мянган төгрөгийн 1 ажил гүйлгээг мэдээлээгүй орхигдуулсныг аудитын явцад залруулан мэдээлүүлсэн.

4.3 Албан шаардлага

Байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд тээврийн хэрэгсэл байхгүй байхад тайлант жилд 1,170.0 мянган төгрөгийн тээвэр шатахууны зардал зарцуулсан. Шатахууны зардлыг зарцуулахдаа талноор төрөл бүрийн тээврийн хэрэгслийг ажилд явуулж, тооцоог бодохдоо Зам тээвэр хөгжлийн сайдын 390 дүгээр тушаалаар тогтоосон шатахуун зарцуулалтыг нормыг баримтлаагүй. Тээврийн хэрэгслийн суудлын бага оврын, том оврын тээврийн хэрэгсэл зэргийг үл хамааран 100 км -т дунджаар 15 л зарцуулахаар тооцоо бодсон. Өмнөх оны санхүүгийн аудитаар шатахууны зарцуулалттай холбоотой зөвлөмж хүргүүлсэн боловч хэрэгжилт хангалтгүй байна. Энэ нь Зам тээврийн хөгжлийн сайдын 390 дүгээр тушаалаар баталсан "Автомашинь 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-тай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Урсгал зардалтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Аймгийн засаг даргын Б/159 дүгээр захирамжаар Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн 3 инженер онцгой комиссын шуурхай штабын бүрэлдэхүүнд орж ажилласан тул 4, 5, 6 сар, 9, 10, 11, 12 сард нийт 2,472.6 мянган төгрөгийн илүү цагийн хөлс олгохдоо Засгийн газрын 382 дугаар тогтоолын "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журмын хавсралт"-ын дагуу нэмэгдэл хөлс тооцож олгох хуудсыг хавсаргаагүй анхан шатны баримт хангалтгүй, захирлын тушаалыг үндэслэн илүү цагийн хөлс олгосон байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Илүү цагийн хөлс тооцож олгохдоо нэмэгдэл хөлс тооцож олгох хуудсыг хавсаргаж, баталгаажуулж байх.

2. Бараа материалтай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардлаас компьютерын хард, рам зэрэг зүйлс худалдан авсан байна. Энэ нь Сангийн сайдын 2021 оны "Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай" 190 дүгээр тушаалын "210406-Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл нь Байгууллагын албан байрны тохижилт, цэвэрлэгээ болон аж ахуйн хэрэгцээний

зориулалтаар худалдан авсан бараа материал, эд зүйлс, тухайлбал: угаалгын нунтаг, цэвэрлэгээний бодис, хэрэгсэл, цай кофе гэх мэт бага үнэтэй буюу түргэн элэгдэх эд зүйлсийг худалдан авч шууд зарлагадах үед гарсан зардлыг энэ ангилалд бүртгэнэ. Мөн хүчний байгууллагын нормд тавигддаг саван, ариун цэврийн хэрэглэлийн зардлууд энд хамаарна” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Бага үнэтэй түргэн элэгдэх зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Мэдээлэл шуурхай удирдлагын төв	4	15,587.9	1	10,865.4			1	1,170.0	2	3,552.5